

## Гачууртын хороо

1962-12-6-нд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 202 дугаар зарлигаар Налайх хотод харьяалуулан Хонхор, Горкийн хороо захиргаадыг тус тус байгуулжээ.

1964-7-29-нд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 135 дугаар зарлигаар Улаанбаатар хотын харьяа гачууртын хороо захиргааг Төв аймагт шилжүүлэн харьяалуулжээ.

1965-4-14-нд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 79 дүгээр зарлигаар Нийслэл Улаанбаатар хотын Ардын Депутатуудын Хурлын харьяа Ажилчин, Найрамдал, Амгалан, Зүүнсэлбэ, Сүхбаатар, Хоршоолол, Чингэлтэй, Толгойт, Октябрь, Төмөр замын хороог татан буулгаж, Сүхбаатар Октябрийн, Ажилчин, Найрамдлын районыг байгуулж Улаанбаатар хотын районы АДХ-ын сонгуулийг орон нутгийн хурлын 7 дахь удаагийн ээлжит сонгуультай хамтатган явуулахаар тогтоожээ.

1965-12-9-нд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 250 дугаар зарлигаар Налайх хотыг район эрхтэйгээр Улаанбаатар хотод харьяалуулж Налайх, хотын харьяаны хонхор, Горхийн хороодыг татан буулгажээ.